

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

2018 оны 02 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 169/48

Захиргааны хэм хэмжээний
акт Улаанбаатар хот
2018 оны 05 сарын 14-ны
өдрийн 3897 дугаарт бүртгэв.

Жагсаалт, шалгуур үзүүлэлт, заавар, маягт батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.11 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний өвчин, гэмтлийн жагсаалт"-ыг нэгдүгээр, "Байнгын асаргаа шаардлагатай 0-16 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өвчин, гэмтлийн жагсаалт"-ыг хоёрдугаар, "Байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийг үнэлэх шалгуур, үзүүлэлтийг гуравдугаар, "Байнгын асаргаа шаардлагатай иргэн, хүүхдийг тодорхойлох заавар"-ыг дөрөвдүгээр, "Байнгын асаргаа шаардлагатай иргэн, хүүхдийн тодорхойлолт маягт"-ыг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Байнгын асаргаа шаардлагатай иргэнийг болон асаргаанд байх хугацааг үнэн зөв тогтоох, нийгмийн халамжийн тэтгэмж, тусламжид хамруулахад баталсан жагсаалт, шалгуур, үзүүлэлт, заавар маягыг мөрдлөг болгон ажиллахыг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, аймаг, нийслэл, дүүргийн Эрүүл мэндийн газар (төв), Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар (хэлтэс)-ын дарга нарт тус тус үүрэг болгосугай.


3. Тушаалыг хэрэгжүүлж ажиллах эмч, мэргэжилтнүүдийг сургалтад хамруулж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газар, Эрүүл мэндийн хөгжлийн төвд тус тус даалгасугай.

4. Уг тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар, Эрүүл мэндийн яамны Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газарт тус тус үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2012 оны А/55/360 дугаар хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

6. Энэхүү тушаалыг 2018 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.






**БАЙНГЫН АСАРГАА ШААРДЛАГАТАЙ АХМАД НАСТАН, ХӨГЖЛИЙН
БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ ӨВЧИН, ГЭМТЛИЙН ЖАГСААЛТ**


№	Өвчний нэр, үе шат	Өвчний олон улсын код	Эмчлэн эрүүлжүүлж, нөхөн сэргээх хугацаа
1. ХАЛДВАРТ ӨВЧИН			
1.1	Сүрьеэгийн мэнэн хүнд хэлбэр (өөртөө үйлчлэх чадваргүй)	A17.0	24 сар
1.2	Нурууны ясны болон тулгуур эрхтний сүрьеэгийн мэс засал хийлгэсний дараах хүндрэлийн үе	A18.01, A18.03	мэс засал хийлгэснээс хойш 06-12 сар хүртэл
1.3	Сүрьеэгийн улмаас эрхтэн тогтолцооны талаас дахин сэргэхгүй өөрчлөлтөнд орсон (менингит, яс, үе мөчний сүрьеэ, уушгиний сүрьеэгийн хүндрэлийн улмаас мэс засал хийх заалтгүй, амьсгал зүрх судасны архаг дутмагшилтай) тохиолдол	A17.0, A18.0, A19.8, A15.0-8	24 сар
1.4	ХДХВ/ДОХ-ийн халдварын дагалдах халдварын бүхий л эд эрхтэн системийг хамарсан хүндрэлийн үе	B20.0, B20.2, B20.6-7, B21.0-8, B22.0-2	24 сар
1.5	Бруцеллөз өвчний эзэнгшил бүрэн алдсан (өөртөө үйлчлэх чадваргүй)	A23	24 сар
1.6	Хачигт энцефалитын эрхтэн, тогтолцооны саажилтын хүнд хэлбэр, тэнэгрэл	A84	24 сар
2. СЭТГЭЦИЙН БОЛОН ЗАН ҮЙЛИЙН ЭМГЭГ			
2.1	Альцгеймерийн өвчний хэсэгчилсэн тэнэгрэлд орж өөртөө үйлчлэх чадваргүй, бусдын асрамж зайлшгүй шаардлагатай үе	F00	24 сар
2.2	Судасны өвчний гаралтай хэсэгчилсэн тэнэгрэлд орж өөртөө үйлчлэх чадваргүй, бусдын асрамж зайлшгүй шаардлагатай үе	F01, F02, F02.2, F02.3, F02.8.	36 сар
2.3	Зан төрхийн гүнзгий өөрчлөлттэй, ухамсар ухаан бүрийтэн балартал, солиорол бүхий уналт таталттай үе	F 07.8	36 сар

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМ
ТБАГУУГ
ХУУЛБАР**
 Гарын үсэг: _____
 18 он 04 сар 30 өдөр


2.4	Шизофрени өвчний солиорлын шинжүүд бүдэг буюу үлдэц хэлбэрээр илэрч, бие хүний гүнзгий өөрчлөлтөд орж, засрал сайжралд ордоггүй, бусдын хараа хяналт, асрамж шаардлагатай үе	F20.0, F20.1, F20.2, F20.3, F20.4, F20.6, F20.8, F21, F22.	36 сар
2.5	Шизофрени өвчний төгсгөлийн үе буюу үлдэц бүхий солиорлын шинжтэй, бие хүний гүнзгий өөрчлөлт тод илэрч, бие даан амьдрах чадваргүй, бусдын хараа хяналт, асрамж шаардлагатай үе	F20.5	36 сар
2.6	Шизоаффектив эмгэгийн солиорол бүхий сэтгэл хөөрөх, гутрах шинжүүд ээлжлэн тасралтгүй илэрч буй үе	F25	36 сар
2.7	Оюуны хүндэвтэр хомсдол (IQ 35-49) /Насанд хүрсэн хүний сэтгэл зүйн нас 6-9 насны хүүхдийнхтэй ижил түвшний хөгжилтэй/	F71	36 сар
2.8	Оюуны хүнд хомсдол (IQ 20-34) /Насанд хүрсэн хүний сэтгэл зүйн нас 3-6 насны хүүхдийнхтэй ижил түвшний хөгжилтэй/	F72	36 сар
2.9	Оюуны гүнзгий хомсдол (IQ 20 хүртэл) /Насанд хүрсэн хүний сэтгэл зүйн нас 3 наснаас бага хүүхдийнхтэй ижил түвшний хөгжилтэй, байнгын асаргаа шаардлагатай үе	F73	36 сар
2.10	Аутизмын хүрээний эмгэгүүд /хүнд хэлбэрүүд/	F84	36 сар
2.11	Өтлөлтийн үеийн солиорол	F06	36 сар
3. ДОТРЫН ӨВЧИН			
3.1	Зүрхний архаг дутагдал а/атеросклероз, зүрхний шигдээс, кардиомиопати, артерийн гипертензи, хэрэх, зүрхний төрөлхийн ба бусад олдмол эмгэг хамаарна б/ ЗАД-ын "D" шат, ЦЭД IV, Систолын дутагдал, ачаалал даах чадвар буурсан үе	I50, I70, I25, I10 Q20	24 сар
3.2	Уушигны артерийн анхдагч, хоёрдогч даралт ихсэлт CPASP≥60 мм Мөнгөн усны багана	I27.0	24 сар
3.3	Ревматоид артрит Өндөр идэвхжилтэй, хөдөлгөөний үйл ажиллагааны алдагдал IV зэрэг эсвэл түгмэлээр эрхтэн тогтолцоог гэмтээсэн ба үйл ажиллагааны дутагдал илэрсэн, өөрөө өөртөө үйлчлэх чадваргүй үе	M05	24 сар




3.4	Амьсгалын эрхтэний гаж хөгжил, дутуу хөгжил, нуруу цээжний хэнхэрцгийн деформаци, фиброторакс Амьсгалын дутагдалын III зэрэг, ЗАД-ын "D" үе шат Спирографи: VC≤50%, MLV50%, FEV1/ VC≤40%, ЭхоКГ: баруун ховдлын агших чадвар буурч уушгины гемодинамик алдагдах үе	Q33, Q67, J94.1	36 сар
3.5	Амьсгалын архаг дутагдал а/. Уушигны завсрын эдийн эмгэгүүдийн улмаас үүссэн фиброз, хөндий б/. Уушигны фиброз: зөгийн үүрийн шинж, амьсгалын архаг дутагдал III зэрэг, ЗАД-ын "D" үе шат	J84.9	36 сар
3.6	Гуурсан хоолой тэлэгдэх өвчин Амьсгалын дутагдалын III зэрэг, уушгины цус алдалтын улмаас цус багадалтын III зэрэг, бөөрний амилоидозын улмаас бөөрний дутагдалын III зэрэг, тураалын III зэрэг, ЗАД-ын "C", "D" үе шатын аль нэг илэрсэн	J47	36 сар
3.7	Гуурсан хоолойн багтраа Амьсгалын дутагдалын III зэрэг, уушгины цус алдалтын улмаас цус багадалтын III зэрэг, бөөрний амилоидозын улмаас бөөрний дутагдалын III зэрэг, тураалын III зэрэг, ЗАД-ын "C", "D" үе шатын аль нэг илэрсэн үе	J45	36 сар
3.8	Уушигны архаг бөглөрөлт өвчин Амьсгалын дутагдал III зэрэг, ЗАД-ын "D" үе шат, өөртөө үйлчлэх чадвар алдалт III зэрэг, Спирографи: FEV1≤ 30%, FEV1/ F VC≤0.7, ЭхоКГ: баруун ховдлын агших чадвар буурч уушгины гемодинамик алдагдах үе	J44	36 сар
3.9	Бөөрний дутагдал Бөөрний архаг дутагдал II б, III үе (сийвэнгийн креатинин 600 мкмоль/ ба түүнээс дээш (өөртөө үйлчлэх чадваргүй тохиолдол)	N18	24 сар
3.10	Чихрийн шижингийн хожуу үеийн хүндрэлтэй, том ба жижиг судасны хүндрэлийн улмаас (хараа бүрэн алдагдсан, гемодиализад ордог эсвэл бөөр шилжүүлэн суулгах мэс засал хийлгэсэн, шаркогийн хөл үүссэн) эрхтэн тогтолцооны архаг дутагдалтай	E11	24 сар




3.11	Нурууны эмгэгүүд (дорсопати, нуруу гулсах, спондилопати) Хөдөлгөөний үйл ажиллагааны алдагдал IV зэрэг эсвэл дотор эрхтэний үйл ажиллагааны алдагдалтай үе	M54	36 сар
3.12	Ясны бүтцийн эмгэгүүд (Хүнд хэлбэрийн ясны сийрэгжилт, яс зөөлрөлт)	M80-M82	24 сар
3.13	Улаан хоолойн сорвижилт нарийсал, ахалази ээнэгшил алдагдсан үе	K22	24 сар хүртэл
3.14	Элэгний хатуурал, декомпенсацтай /Чайльд-Пьюгийн "С" зэрэг/	K74	24 сар
3.15	Нарийн, бүдүүн гэдэсний эмгэг а/ Кроны өвчний хүнд хэлбэр б/ Бүдүүн гэдэсний шархлаат үрэвслийн хүнд хэлбэрийн үе	K50	24 сар
3.16	Насны доройтол /80-аас дээш насанд хавсарсан эмгэгтэй үе/	R54	36 сар
4. ЦУСНЫ ӨВЧИН			
4.1	Цусны хурц лейкеми төгсгөлийн шат	C91, C92	24 сар
4.2	Цусны архаг лейкеми төгсгөлийн шат	C91.1, C92.1	24 сар
4.3	Лимфома, миеломын хүнд хэлбэр, төгсгөлийн шат	C90, C83, C81	24 сар
4.4	Миелодисплази хам шинж, хүнд хэлбэр	D46	24 сар
4.5	Цус төлжилгүйдлийн цус багадалт, төгсгөлийн шат	D61	24 сар
4.6	Гемофили-Төрөлхийн цус бүлэгнэлтийн алдагдалт эмгэг, Вильбрандийн өвчин	D366	24 сар
5. МЭДРЭЛИЙН ӨВЧИН			
5.1	Тархины харвалтын (инсульт) уршиг үлдэц байдал, судасны мэс заслын урхаг (Нэг, хоёр талын хөшүүн саажил, хэл яриа, дуу хоолой, залгихуйн өөрчлөлт, танин мэдэхүйн бууралт, тэнэгрэл, эпилепсийн уналт таталтууд)	I69	36 сар
5.2	Нугасны харвалтын (миелоишеми, гематомиели) үлдэц байдал Хөдөлгөөн-мэдрэхүйн дөрвөлсөн, хос саажил, аарцгийн эрхтний хямрал	G99.4	36 сар
5.3	Тархины бүрхэвч, тархины эдийн үрэвслийн урхаг үлдэц (менингит, энцефалит, менингоэнцефалит) тархи усжилт, тэнцвэргүйдэл, тэнэгрэл, шээс задгайрал, эпилепсийн таталтууд зан төрхийн эмгэг бүхий үе	G03,G04	36 сар




5.4	Нугасны үрэвсэл (миелит), мэнэнт-нугасны үрэвсэл (менингомиелит), нугасны саа, урхаг үлдэц а/ доод мөчний хүнд зэргийн хөдөлгөөн-мэдрэхүйн хос саажил, аарцгийн эрхтний хямрал б/ дөрвөл саажил, аарцгийн эрхтний хямрал	G04	36 сар
5.5	Тархмал хатуурал, түүнтэй төст эмгэг(Хараа, хэл ярианы өөрчлөлт, хавсарсан саажил, тэнцвэрийн өөрчлөлт, аарцгийн эрхтний хямрал)	G35	36 сар
5.6	Тархи нугасны тархмал үрэвслийн (энцефаломиеелит) урхаг (Залгиур хоолойн саажил, мөчдийн дөрвөлсөн хөдөлгөөн-мэдрэхүйн саажил, татангир, аарцгийн эрхтний хямрал)	G04.9	36 сар
5.7	Булчин даамжрах сөнөрөл (миодистрофи, миотони) (Хөдөлгөөн үлэмж хязгаарлагдаж, булчин хатангиртсан, татангир, явж чадахгүй, суугаа байрлалтай)	G71	36 сар
5.8	Нугас-булчин хатангирал-спинал амиотрофи, мэдрэл-булчин хатангирал-неврал амиотрофи (Хөдөлгөөн үлэмж хязгаарлагдаж, булчин хатангиртсан, татангир)	G10-G13	36 сар
5.9	Хатангиралт хатуурал (тагнай, залгиур хоолойн саа, мөчдийн хатангирт саажил)	G12-2	36 сар
5.10	Булчин сулрал (миастени) Булчингийн тархмал сулрал, булчин сулрах криз	G70	36 сар
5.11	Паркинсоны өвчин, паркинсонизм (Даамжирч, хөдөлгөөн үлэмж хомсдсон)	G20	36 сар
5.12	Эмгэг хөдөлгөөнтөл (гиперкинез) (Толгой, хүзүү, гар, хөлийн эмгэг хөдөлгөөнт гаж байрлал)	R25.8	36 сар
5.13	Нугас бага тархи, бага тархины тэнцвэргүйдэл (спиноцеребрал, церебрал атакси) (Тэнцвэр, хэл ярианы өөрчлөлт гүнзгий)	G31	36 сар
5.14	Тархи, нугасны гэмтлийн дараах урхаг байдал (Тархи, нугасны мэс заслын дараах урхаг эмгэг, тархины мэдрүүл ба мөчдийн саа, саажил, тэнцвэрийн өөрчлөлт, аарцгийн эрхтний хямрал)	G81	36 сар



5.15	Тархи, нугасны хавдрын мэс заслын дараах үлдэц байдал (гүнзгий голомтот өөрчлөлт, саа, уналт, таталт)	G41	24 сар
5.16	Олон мэдрүүлийн саа (полиневропоти) /Дөрвөн мөчний гүнзгий саа/	G82.5	24 сар
5.17	Үлдэц бүхий органик тархи, тархи, нугасны гаж хөгжил, гидроцефали, нугас хөндийтөл (сирингомиели) Арнольд-Киарын гажиг, эвэрхий (Танин мэдэхүй, оюуны хомсдол, мөчний саажил, хатангирал, мэдрэхүйн өөрчлөлт, тагнай, залгиурын саа, шээс задгайрах)	Q70	36 сар
6. НҮДНИЙ ӨВЧИН			
6.1	Зохих эмчилгээ хийлгэсний дараа хамгийн сайн харж байгаа нүдний харааны чадал 0,05(3/60)-аас бага, эсвэл харааны талбайн алдагдал 10 ⁰ -аас дотогш харахад хүргэж байгаа нүдний бүх төрлийн эмгэг, гэмтэл, хавдар зэрэг	H54	36 сар
7. ЧИХ, ХАМАР, ХООЛОЙН ӨВЧИН			
7.1	Дунд чихний идээт хүндрэл, тархины буглаа, мэнэн	H70	мэс засал хийлгэснээс хойш 12сар хүртэл
7.2	Хамрын төрөлхийн гажиг (Гадна хамаргүй хоан битүү гэх мэт, хамрын төрөлхийн гаж хөгжил)	Q31, Q30	нөхөн сэргээх мэс засал хийлгэснээс хойш 12 сар хүртэл
7.3	Төвөнхийн олон тахилттай папиломатоз	J38.7	36 сар
8. ХОРТ ХАВДАР			
8.1	Бүх төрлийн хорт хавдрын төгсгөлийн буюу 3-4-р үе шат	C00-C97	36 сар
8.2	Хавдрын улмаас мөч, мэдрэхүйн болон хэл ярианы эрхтэн тайрах мэс заслын дараах байдал		36 сар
8.3	Хорт хавдрын өвөрмөц эмчилгээний дараах амин чухал эрхтний үйл ажиллагааны дутагдалаар илрэх хүндрэлүүд		36 сар
8.4	Хорт хавдрын эмчилгээний дараа амьсгалын (трахеостоми), хоол боловсруулах замын (колостоми, ентэростоми, гастростоми) болон шээс дамжуулах замын (нефроостоми, цистостоми) цоргууд тавигдсан.		36 сар
9. ГЭМТЭЛ, СОГОГИЙН ӨВЧИН			
9.1	Фиброзный дисплазий-Ясны эдийн дутуу	M85	36 сар



	хөгжлийн хүнд хэлбэр дээд доод мөчийг хамарсан үе		
9.2	Нугасны хүнд хэлбэрийн гэмтэлтэй холголт,цооролт үүссэн зөөлөн эдийн их хэмжээний дутмагшилтай үе	S14	36 сар
9.3	Гэмтлийн дараах доод мөчний саажилт	G83.1	36 сар
9.4	Гэмтлийн дараах дөрвөн мөчний саажилт	G82	36 сар
9.5	Тархины хүнд хэлбэрийн гэмтэл	S00	36 сар
9.6	Хоёр гар аль нэг түвшинд мухар	S68	36 сар
9.7	Хоёр шилбэ аль нэг түвшинд мухар	S88	36 сар
9.8	Хоёр гуя аль нэг түвшинд мухар	S78	36 сар
9.9	Хоёр түнхний үеэр тайрагдсан	S78	36 сар
9.10	Аарцгийн хөндийн эрхтэний гэмтэлтэй хавсарсан нийлмэл хугарлууд	S70-S72	36 сар
9.11	Дунд чөмөгний хүзүү болон гандан хэсгийн хуурамч үе үүсч ясны тэжээл, гишгэх үйл ажиллагаа алдагдсан болон бусад эрхтэн системийн үйл ажиллагааны алдагдалтай хавсарсан /гереонтологийн үнэлгээний хүнд, хүндэвтэр хэлбэр/	S72.0	36 сар
9.12	Түнхний үений төрөлхийн дутмаг хөгжил болон мултралыг мэргэжлийн эмчийн хяналтанд тасралтгүй үе шаттайгаар эмчлүүлж байгаа тохиолдолд	Q65	24 сар
9.13	Түлэгдэлтийн 3-дугаар зэргээс дээш, биеийн гадаргуугийн 50%- с дээш талбай бүхий шархтай 2 ба түүнээс дээш том үений татагдаж наалдсан сорви бүхий үений өөрчлөлттэй	T20-T32	36 сар




Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр,
нийгмийн хамгааллын сайдын 2018
оны 02 дугаар сарын 23-ны өдрийн
А/64/18 дугаар хамтарсан тушаалын
хоёрдугаар хавсралт

**БАЙНГЫН АСАРГАА ШААРДЛАГАТАЙ 0-16 ХҮРТЭЛХ НАСНЫ ХӨГЖЛИЙН
БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ӨВЧИН, ГЭМТЛИЙН ЖАГСААЛТ**


№	Өвчний нэр, үе шат	Өвчний олон улсын код	Эмчлэн эрүүлжүүлж, нөхөн сэргээх хугацаа
1. Мэс заслын өвчин			
1.1	Уушгины архаг идээт үрэвсэл	J 41	мэс заслын дараа 12 сар хүртэл
1.2	Цэсний сувгийн төрөлхийн битүүрэл	K 83.1	мэс заслын дараа 36 сар хүртэл
1.3	Үүдэнвенийн даралт ихсэх хам шинж	K 74.6	мэс заслын дараа 36 сар хүртэл
1.4	Ясны архаг идээт үрэвсэл	M 86.2	цорго хаасны дараа 6 сар хүртэл
1.5	Нарийн бүдүүн гэдэсний цорго гаргасан	K 63.1	мэс заслын дараа 12 сар хүртэл
1.6	Хошноого шулуун гэдэсний гаж хөгжил	Q 42.2	мэс заслын дараа 12 сар хүртэл
1.7	Улаан хоолойн химийн түлэгдэл	T 26.1	мэс заслын дараа 24 сар хүртэл
1.8	Улаан хоолойн битүүрэл	Q 39	пластик мэс заслын дараа 24 сар хүртэл
1.9	Элэг цэсний хагалгааны дараах байдал	K 91	мэс заслын дараа 12 сар
1.10	Хэвлийн гялтангийн түгээмэл үрэвсэл	K 65.0	мэс заслын дараа 6 сар хүртэл
1.11	Бөөрний өмөн хагалгааны дараах байдалтай /Вильямсийн хавдар/	C 64.0	36 сар
1.12	Ил давсаг	Q 64.1	36 сар
2. Нүдний өвчин			
2.1	0-16 насны хүүхдүүдэд зохих эмчилгээ хийлгэсний дараа хамгийн сайн харж байгаа нүдний харааны чадал 0,05(3/60)-аас бага, эсвэл харааны талбайн алдагдал 10 ⁰ -аас дотогш харахад хүргэж байгаа нүдний бүх төрлийн эмгэг, гэмтэл, хавдар зэргийг хамруулан оруулах	Ямар ч шалтгааны улмаас ДЭМБ-ын тодорхойлолтоор хараагүй гэсэн ангилалд хамаарагдаж буй өвчтөнүүд	24 сар
3. Чих хамар хоолойн өвчин			
3.1	2 чихний төрөлхийн дутуу хөгжил	Q16.0	6 нас хүртэл

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМ
ТБАГУУГ
ХУУЛБАГ УНД
Гарын үсэг
2018 оны 04 сар 30 өдөр


		H 90.5	асаргаанд байх ба 16 наснаас өмнө суваг нээх мэс засал хийгдсэнээс 12 сар хүртэл
3.2	2 талын дуу хүлээн авах хэлбэрийн тодорхойгүй дүлий	H.90.5	36 сар
3.3	2 талын дуу хүлээн авах хэлбэрийн хүнд зэргийн бууралт	H 90.3	36 сар
3.4	Дунгийн суулгацтай хүүхэд төрөлхийн 2 талын дуу хүлээн авах хэлбэрийн хүнд зэргийн дүлий (1 талд тавьсан бол)	H 90.5	мэс заслын дараа 36 сар хүртэл
3.5	Дунгийн суулгацтай хүүхэд (төрөлхийн 2 талын дуу хүлээн авах хэлбэрийн хүнд зэргийн дүлий/) 2 талд тавьсан бол	H 90.5	мэс заслын дараа 36 сар хүртэл
3.6	Хамрын төрөлхийн гажиг (Гадна хамаргүй хоан битүү гэх мэт, хамрын төрөлхийн гаж хөгжил)	Q31 Q30	нөхөн сэргээх мэс засал хийснээс хойш 12 сар хүртэлх
3.7	Мөгөөрсөн хоолойд гуурс тавих эмчилгээ хийгдсэн	J38	мэс заслын дараа 6 сар хүртэл
3.8	Мөгөөрсөн хоолойд амьсгалуулах байнгын гуурстай байх	J38	36 сар
4. Мэдрэлийн өвчин			
4.1	Хүүхдийн тархины саа өвчин	G 80	36 сар
4.2	Эпилепсийн хүнд хэлбэр	G 40	36 сар
4.3	Төрөлхийн булчин сулрал	G 70	36 сар
4.4	Тархины бүрхэвч, тархины эдийн үрэвслийн урхаг үлдэц (менингит, энцефалит, менингоэнцефалит)	G 00- G 04 G 91.9	36 сар
4.5	Тархины хавдар	C 71.9	36 сар
4.6	Хүүхдийн нугас – булчингийн хатингир ба түүнд хамаарах хам шинжүүд	G12	36 сар
4.7	Бичил тархи	Q02	36 сар
5. Төрөлхийн гажиг			
5.1	Төрөлхийн дээд мөчгүй	Q71.0	36 сар
5.2	Төрөлхийн бугалга ба шуугүй; төрөлхийн бугалга ба шуугүй боловч 1 ба 2 талд сарвуутай	Q71.1	36 сар
5.3	Төрөлхийн доод мөчгүй	Q72.0	36 сар
5.4	Төрөлхийн шилбэ ба тавхайгүй	Q72.2	36 сар
5.5	Тархины төрөлхийн том энцефалоцеле	Q 01	36 сар
5.6	Нугасны төрөлхийн хүнд хэлбэрийн ивэрхий	Q 06	36 сар
5.7	Тархины төрөлхийн хүнд хэлбэрийн усжилт	Q 03.8-03.9	36 сар
6. Зүрх судас, холбогч эдийн өвчин			




6.1	Зүрхний төрөлхийн хавсарсан хөх гажгууд	Q 20.0-28.0	36 сар
6.2	Тогтолцооны чонон яр (хүнд зэрэг)	M32	36 сар
6.3	Дерматомиозит	M33	36 сар
6.4	Тогтолцооны склеродермийн хүнд хэлбэр	M34	36 сар
7. Хоол боловсруулах тогтолцооны өвчин			
7.1	Ээнэгшил алдагдсан элэгний хатуурал	K 74	36 сар
8. Булчирхайн өвчин			
8.1	Чихрийн шижингийн хүнд хэлбэр	E 10	36 сар
8.2	Ахондродисплази	Q77.4	36 сар
8.3	Өнчин тархины аденом	C 75	36 сар
8.4	Хүнд хэлбэрийн гипотиреоз	E03.1	36 сар
8.5	Гистоцитоз Х – нэг бөөмт эсийн хорт хавдар	D76.3	36 сар
9. Бөөр, шээс дамжуулах замын өвчин			
9.1	Бөөрний өвчний эцсийн шат	N 18.6	сар
10. Цусны эмгэг			
10.1	Цусны хавдар	C 90-96	36 сар
10.2	Гемофили - Төрөлхийн цус бүлэгнэлтийн алдагдалт эмгэг, вильбрандын өвчин	D366	36 сар
10.3	Апластик анеми - Төлжилтгүй цус багадалт	D61	36 сар
10.4	Гистоцитоз Х –нэг бөөмт эсийн хорт хавдар	D76.3	36 сар
11. Хавдар			
11.1	Хорт хавдрууд – (хавдрын 3-4-р үе шат)	C80	мэс засал, эмчилгээний дараах 12-36 сар
12. Амьсгалын эрхтэний өвчин			
12.1	Амьсгалын эрхтэний гаж хөгжлийн улмаас амьсгалын дутлын 3-р зэрэгт орсон	Q33	36 сар
12.2	Гуурсан хоолойн багтрааны улмаас амьсгалын дутлын 3-р зэрэгт орсон	J45	24 сар
13. Оюуны хөгжлийн бэрхшээл, удамшлын эмгэг			
13.1	Оюуны хүндэвтэр хомсдол (IQ 35-49)	F71	24 сар
13.2	Оюуны хүнд хомсдол (IQ 20-34)	F72	36 сар
13.3	Оюуны гүнзгий хомсдол (IQ 20 хүртэл) /Насанд хүрсэн хүний сэтгэлзүйн нас 3 наснаас бага хүүхдийнхтэй ижил түвшний хөгжилтэй, байнгын гардан асаргаа шаардлагатай бол/	F73	36 сар
13.4	Аутизмын хүрээний эмгэгүүд	F84	36 сар



13.5	Дауны хам шинж	Q90	36 сар
14. ГЭМТЭЛ, СОГОГИЙН ӨВЧИН			
14.1	Фиброзный дисплазий - Ясны эдийн дутуу хөгжлийн хүнд хэлбэр дээд доод мөчийг хамарсан	M85	36 сар
14.2	Нугасны хүнд хэлбэрийн гэмтэлтэй холголт, цооролт үүссэн зөөлөн эдийн их хэмжээний дутмагшилтай	S14	36 сар
14.3	Гэмтлийн дараах доод мөчний саажилт	G83.1	36 сар
14.4	Гэмтлийн дараах дөрвөн мөчний саажилт	G82	36 сар
14.5	Тархины хүнд хэлбэрийн гэмтэл	S00	36 сар
14.6	Хоёр гар аль нэг түвшинд мухар	S68	36 сар
14.7	Хоёр шилбэ аль нэг түвшинд мухар	S88	36 сар
14.8	Хоёр гуя аль нэг түвшинд мухар	S78	36 сар
14.9	Хоёр түнхний үеэр тайрагдсан	S78	36 сар
14.10	Аарцгийн хөндийн эрхтэний гэмтэлтэй хавсарсан нийлмэл хугарлууд	S70-S72	36 сар
14.11	Дунд чөмөгний хүзүү болон гандан хэсгийн хуурамч үе үүсч ясны тэжээл, гишгэх үйл ажиллагаа алдагдсан болон бусад эрхтэн системийн үйл ажиллагааны алдагдалтай хавсарсан /хүнд, хүндэвтэр хэлбэр/	S72.0	36 сар
14.12	Түнхний үений төрөлхийн дутмаг хөгжил болон мултралыг мэргэжлийн эмчийн хяналтанд тасралтгүй үе шаттайгаар эмчлүүлж байгаа тохиолдолд	Q65	24 сар
14.13	Түлэгдэлтийн 3-дугаар зэргээс дээш, биеийн гадаргуугийн 50%- с дээш талбай бүхий шархтай 2 ба түүнээс дээш том үений татагдаж наалдсан сорви бүхий үений өөрчлөлттэй	T20-T32	36 сар





**БАЙНГЫН АСАРГАА ШААРДЛАГАТАЙ АХМАД НАСТАН, ХӨГЖЛИЙН
БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭН, ХҮҮХДИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР, ҮЗҮҮЛЭЛТ**

Өдөр тутмын үйл ажиллагаа	Үнэлэх шалгуур	Оноо
Хооллох	Тусламжгүйгээр хооллоно.	2
	Талх зүсэх, цөцгийн тос түрхэх зэрэгт тусламж шаардана.	1
	Хооллоход бүрэн тусламж шаардана.	0
Хувцаслах	Хувцас сонгох, өмсөхөд тусламж шаардахгүй.	2
	Үдээс үдэх, товч товчлох зэрэгт тусламж шаардана.	1
	Хувцаслахад туслалцаа шаардана, бүрэн хувцаслаж чадахгүй.	0
Усанд орох /ванн, шүршүүр/	Усанд тусламжгүйгээр орно.	2
	Биеийн нэг хэсэг / нуруу/ угаахад тусламж шаардана.	1
	Биеийн 2 хэсгээс дээш угаахад тусламж шаардана, усанд бие дааж орж чадахгүй.	0
Хөдөлгөөн	Гэр дотуур болон гадагш чөлөөтэй явж чадна /таяг, түшлэгтэй байж болно.	2
	Хүний тусламж шаардан гэр дотуур явна.	1
	Тусламжгүйгээр орноос босч чадахгүй.	0
Бие засах	Туслагчгүйгээр ариун цэврийн өрөө рүү ганцаараа явж, суултуурт суух, ариун цэврийн цаас ашиглан цэвэрлэж чадна.	2
	Ариун цэврийн өрөө рүү ороход тусламж шаардана, хөтөвч тогтмол ашиглана.	1
	Өтгөн шингэнээ барьж чадахгүй.	0
	Шээс болон өтгөнөө барих чадвар сайн, өтгөн	2


**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМ
ТБАГУУГ
ХҮҮЛБАР ҮНЭН**
 Гарын үсэг: *[Signature]*
 2018 оны сарын 30 өдөр

Өтгөн шингэнээ барих чадвар	шингэнээ өөрөө хянана.	
	Шээс, өтгөнөө гаргахад бургуй ба шээлгүүр ашиглана. Хөтөвч тогтмол хэрэглэнэ.	1
	Байнгын бургуй ба колостомийн тусламжтайгаар гаргана.	0
Нийт оноо		

Тайлбар: Шалгуур, үзүүлэлтийн дагуу 0-6 оноотой тохиолдолд байнгын асаргаа шаардлагатай гэж үзнэ.


ОЮУНЫ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ, СЭТГЭЦИЙН ХҮНД ХЭЛБЭРИЙН ЭМГЭГТЭЙ ХҮҮХЭД БА ИРГЭНИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР, ҮЗҮҮЛЭЛТ


Сэтгэцийн эмгэгүүд	Үнэлэх шалгуур	тийм	үгүй
F00 , F01 , F02 , F02.2 F02.3 , F02.8 , F07.8 F71 - F73 , F84	Танин мэдэхүйн дээд мэдрэлийн үйл ажиллагаа буурсан, алдагдсан, хөгжөөгүй.	1	0
	Гэр бүл, орчиндоо, өөртөө аюултай үйлдэл хийх, гэмтэхээс сэргийлж байнгын тасралтгүй хараа хяналтанд байлгах.	1	0
	Хүчирхийлэлд өртөхөөс сэргийлж асран хамгаалагч хамт явдаг.	1	0
	Аливаад шүүмжлэлтэй хандах чадвар муудсан, чадваргүй болсон.	1	0
	Өдөр тутмын, гэр ахуйн, нийгмийн, өөртөө үйлчлэх чадвар буурсан, алдагдсан, хөгжөөгүй.	1	0
	Оюун ухааны чадварууд буурсан, алдагдсан, хөгжөөгүй.	1	0
	Өвчний улмаас өөртөө болон бусдад, нийгэмд аюултай үйлдэл хийж болзошгүй.	1	0
	Өвчний улмаас орон зай, цаг хугацааны баримжаа бүтэн болон хагас алдагдсан.	1	0
	Шаардлагатай эмийг тогтмол уулгадаг.	1	0
	Уналт таталт, ухамсарт ухаан балартлын, солиорол, зан төрхийн өөрчлөлтийн шинж хавсран илэрдэг.	1	0



F20.5 , F25	Позитив шинжүүд (Кататони, хий үзэгдэл, дэмийрэл, сэтгэл хөдлөлийн) шинжүүд үлдэц хэлбэрээр илэрдэг.	1	0
	Бие хүний гүнзгий (сэтгэлгүйдэх зориггүйдэх шинжүүд) өөрчлөлтүүд илэрч байгаа.	1	0
	Өөртөө буюу өвчиндөө шүүмжлэлтэй хандах чадвар буурсан , алдагдсан.	1	0
	Эм уухаас татгалздаг тул гэр бүлийн гишүүд шаардлагатай эмийг тогтмол уулгадаг.	1	0
	Өвчний улмаас өөртөө, бусдад, нийгэмд аюултай үйлдэл хийж болзошгүй.	1	0
	Нийгэм хамт олны дунд дасан зохицох чадвар эрс буурсан, алдагдсан, бие хүний ганцаардлын шинж тод илэрч байгаа.	1	0
	Өвчний дахилт олон, засрал сайжралд ордоггүй.	1	0
	Өөрөө өөртөө үйлчлэх чадвар буурч бие даан амьдрах чадваргүй.	1	0
	Аюулгүй байдлыг хангах шаардлагаар бусдын хараа хяналт, асрамж шаардлагатай.	1	0
	Бие хүний доройтлын шинжүүд (сэтгэл хөдлөл, зориг үйлдэл, дурын өөрчлөлтүүд) илэрдэг.	1	0
Нийт оноо			

Тайлбар: Шалгуур, үзүүлэлтийн дагуу 6–гаас дээш оноотой тохиолдолд байнгын асаргаа шаардлагатай гэж үзнэ.





БАЙНГЫН АСАРГАА ШААРДЛАГАТАЙ АХМАД НАСТАН, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭН, ХҮҮХДИЙГ ТОДОРХОЙЛОХ ЗААВАР

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Байнгын асаргаанд байх шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийг тодорхойлох, асаргаанд байх хугацааг тогтоох, сунгах, цуцлах асуудлыг шийдвэрлэхэд энэхүү зааврыг баримтална.

1.2. Аймаг, дүүргийн Эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгийн Эмнэлэг хяналтын комисс (цаашид “ЭХК), Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс (цаашид ХБХЭМБНХСК), Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн эмнэлэг хяналтын комисс (цаашид СЭМҮТ-ийн ЭХК) эмнэлгийн эмч, сумын эрүүл мэндийн төвийн эрхлэгч их эмч, мэргэжилтнүүд байнгын асаргаа шаардлагатай иргэнийг тодорхойлох үйл ажиллагаанд энэхүү зааврыг ашиглана.

1.3. Заавар нь байнгын асаргаа шаардлагатай иргэнийг тодорхойлох, асаргаанд байх хугацааг сунгах, цуцлах, эмчлэн эрүүлжүүлэх, нөхөн сэргээхтэй холбоотой харилцааг оролцогчид нэг мөр мөрдөж хэрэглэх, нийгмийн халамжийн үйлчилгээг ил тод нээлттэй хүргэхэд чиглэгдэнэ.

1.4. Өвчин гэмтэл нь архагшин эрхтэн, бие махбодын тогтоц, үйл ажиллагаа нь хүндээр гэмтсэний улмаас өөрөө өөртөө үйлчлэх чадваргүй, хэвтрийн дэглэмд бусдын асаргаа сувилгаанд байдаг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхэд, хүндэвтэр болон хүнд хэлбэрийн оюуны бэрхшээлтэй, сэтгэцийн хүнд хэлбэрийн эмгэгтэй иргэн, хүүхдэд “Байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний өвчин, гэмтлийн жагсаалт”, “Байнгын асаргаа шаардлагатай 0-16 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн (цаашид өвчин, гэмтлийн жагсаалт гэх) ба “Байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийг үнэлэх шалгуур, үзүүлэлт” (цаашид шалгуур, үзүүлэлт гэх)-ийг үндэслэн асаргааг тогтооно.

Хоёр. Комиссын үйл ажиллагаа

2.1. ЭХК, СЭМҮТ-ийн ЭХК, сумын эрүүл мэндийн төвийн эрхлэгч их эмч “Эмнэлэг хяналтын комиссын дүрэм”, ХБХЭМБНХСК нь “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрэм”-ийг үйл ажиллагаандаа тус тус баримтлан ажиллана.

2.2. ЭХК-ын хурал нь дарга, нарийн бичгийн дарга, төрөлжсөн мэргэжлийн 3 эмч, ХБХЭМБНХСК-ын хурал нь дарга болон 6 гишүүн, СЭМҮТ-ийн ЭХК-ын хурал нь

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМ
ТЭАГУУГ
ХУУЛБАРУНД
Гарын үсэг:
2018 оны сар 30 өдөр

4-гишүүний бүрэлдэхүүнтэй хуралдах бөгөөд гишүүдийн 80-аас доошгүй хувийн саналаар байнгын асаргааг тогтоох эсэхийг шийдвэрлэнэ.

2.3. Хурлын үед эргэлзээтэй тохиолдолд Эрүүл мэндийн яамны дэргэдэх Мэргэжлийн салбар зөвлөлийн эмч, мэргэжилтнүүд, ХБХЭМБНХ-ын төв комиссын дэргэдэх мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх Зөвлөлийн гишүүдээс мэргэжил арга зүйн зөвлөгөө авч болно.

2.4. Сумын эрүүл мэндийн төв, ЭХК, СЭМҮТ-ийн ЭХК, ХБХЭМБНХСК нь ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлж, явуулын узель, микрофон, электрон урсдаг дэлгэц, зурагт, цахим зарын самбар ашиглах зэргээр шуурхай чирэгдэлгүй үйлчлэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

Гурав. Байнгын асаргаа шаардлагатай иргэнийг тодорхойлох

3.1. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмчлэгч эмч нь бие махбодийн бүтэц, үйл ажиллагаа алдагдсан байдлыг нягтлан магадлах зорилгоор иргэнийг аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо эмчилгээний төв, сэтгэцийн болон төрөлжсөн мэргэжлийн эмчийн үзлэг, оношлогоо шинжилгээнд илгээнэ.

3.2. Өвчин, гэмтлийн жагсаалт, шалгуур үзүүлэлтийн дагуу өрх, төрөлжсөн мэргэжлийн эмч, мэргэжилтнүүд өвчтөний биеийн байдал, үзлэг, оношлогоо, шинжилгээгээр баталгаажсан онош, өвчний явц, үе шат, хүндрэл зэргийг тодорхойлон байнгын асаргаа тогтоох үндэслэлтэй бол комиссын хурлаар хэлэлцүүлнэ.


3.3. Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эрхлэгч их эмч нь өвчтөний биеийн байдал, үзлэг, оношилгоо, шинжилгээгээр баталгаажсан онош, өвчний явц, үе шат, хүндрэл зэргийг тодорхойлон байнгын асаргаа тогтоох асуудлыг шийдвэрлэнэ.

3.4. Байнгын асаргаа шаардлагатай 0-16 хүртэлх насны хүүхдийг Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн (цаашид ЭХЭМҮТ) төрөлжсөн мэргэжлийн бусад эмнэлгийн байгууллагын мэргэшсэн эмчийн үзлэг, оношилгооны дүгнэлт, хэрэв хүүхэд, түүний асран хамгаалагч Улаанбаатар хотод ирж III шатлалын эмнэлгийн дүгнэлт авах боломжгүй тохиолдолд тухайн орон нутгийн хүүхдийн зөвлөх эмчийн дүгнэлт, эсхүл цахимаар авсан ЭХЭМҮТ-ийн эмчийн дүгнэлтийг үндэслэн аймаг, дүүргийн ХБХЭМБНХСК хэлэлцэнэ.

3.5. Эрхтэн системийн гүнзгий дутагдалтай, тээвэрлэх боломжгүй иргэний өвчний онош, үе шатыг бүрэн нотолсон эмчлэгч эмчийн үзлэг дүгнэлт, өөрсдийнх нь хүсэлт зэргийг үндэслэн комиссын гишүүд гэрийн үзлэг хийж, эсхүл тухайн өвчтөний видео бичлэг, зураг зэргийг үндэслэн асаргаа тогтоох асуудлыг хурлаар хэлэлцэнэ.

3.6. ЭХК, СЭМҮТ-ийн ЭХК, ХБХЭМБНХСК нь Өрхийн болон төрөлжсөн мэргэжлийн эмчийн хурлаар иргэний биеийн байдал, үзлэг, шинжилгээ, оношилгоо, онош, өвчтөний үечилсэн дүгнэлттэй танилцан шаардлагатай гэж үзвэл холбогдох үзлэг, шинжилгээг давтан хийлгэсний дараа тухайн иргэнд байнгын асаргааг тогтоох эсэх асуудлыг эцэслэн шийдвэрлэнэ.

3.7. Анх удаа байнгын асаргаа тогтоолгож байгаа иргэний тухайд өвчний оношийг төрөлжсөн мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн эмчээр оношийг баталгаажуулсан байна.



3.8. Өвчин, гэмтлийн жагсаалт, шалгуур үзүүлэлтийн дагуу өвчний онош, үе шат, хүндрэл, үзлэг, шинжилгээ, оношилгооны дүгнэлтийг үндэслэн байнгын асаргаа тогтоохыг комисс хэлэлцэн эцсийн шийдвэрийг гаргана.

3.9. Гадаад улсад удаан хугацаагаар эмчлүүлж байгаа байнгын асаргаа шаардлагатай иргэний асаргааны хугацааг сунгахдаа оршин сууж буй газрын харъяа эмнэлэгт үзлэг, шинжилгээ, эмчлэн эрүүлжүүлэх үйл ажиллагаанд хамрагдаж буй эсэх талаарх эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолт, биеийн байдлын талаарх дүгнэлтийн эх хувь, иргэний хувийн хүсэлт зэргийг үндэслэн тухайн комисс шийдвэрлэнэ.

Дөрөв. Байнгын асаргааны хугацааг тогтоох ба сунгах

4.1. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийг байнгын асаргаанд байх шаардлагатайг тодорхойлсон тохиолдолд өвчин гэмтлийн жагсаалтад заасан хугацааг баримтлан 6-36 сарын хугацаагаар тогтоох буюу сунгана.

4.2. 0-16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдийг тодорхойлох өвчин, гэмтлийн жагсаалтад орсон мэс заслын өвчний үед хагалгаа хийлгэснээс хойшхи заасан хугацааг баримтлан байнгын асаргааг тогтооно.

4.3. Өвчин, гэмтлийн жагсаалтад заасан зарим өвчний үед асаргаанд байх шаардлагатай хугацааг "... сар хүртэл" гэснийг зөвхөн нэг удаа тухайн хугацаагаар тогтоох бөгөөд дахин сунгахгүй.

4.4. Өвчин, гэмтлийн жагсаалтад заасан асаргаанд байх шаардлагатай хугацааны "... сар" гэснийг дээрх хугацаагаар сунгаж, тухайн хугацааг дуусмагц өвчний явц, хүндрэлийг харгалзан үргэлжүүлэн заасан хугацаагаар сунгах, эсэхийг тухайн комисс хэлэлцэн шийдвэрлэнэ.


4.5. Байнгын асаргаанд байх хугацаа дууссан өдрөөс хойш ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний асаргааг ажлыг 10 хоногийн дотор сунгуулах бөгөөд хүндэтгэн үзэх шалтгаангүй тохиолдолд комиссын хурлаар орсон өдрөөс тооцон хугацааг сунгана.

4.6. Төрөлхийн оюуны хөгжлийн бэрхшээлтэй болон сэтгэцийн хүнд хэлбэрийн эмгэгтэй хүнд байнгын асаргаа шаардлагатай хугацааг 36 сараар тогтоож, мөн хугацаагаар сунгана.

4.7. Эрхтэн системийн үйл ажиллагаа алдагдаж, эргэшгүй өөрчлөлтөд орсон хүнд өвчтэй иргэнд байнгын асаргаа шаардлагатай хугацааг 36 сараар тогтоож, мөн хугацаагаар давтан сунгана.

4.8. Байнгын асаргаатай иргэн эмчийн зөвлөсөн эмчилгээ, зөвлөгөөг хэрэгжүүлээгүй, хяналтын үзлэгт хамрагдаагүй тохиолдолд байнгын асаргааны хугацааг цуцлах хүртэлх арга хэмжээ авч болно.

4.9. Байнгын асаргааны хугацааг тогтоох болон сунгахад эрүүл мэндийн байгууллагын цахим мэдээллийн сангаас тухайн иргэний эмнэлгийн тусламж үйлчилгээг авдаг эсэх, 0-16 насны хүүхдийн Эрүүл мэндийн дэвтрийг хөтөлдөг эсэхийг хянаж, шийдвэр гаргахад харгалзана.



Тав. Бусад зүйл


5.1. Байнгын асаргааг тогтоох, сунгах, цуцлахаар гаргасан шийдвэрийг тухайн эрүүл мэндийн байгууллага бүртгэлийн журналд тухай бүр үнэн зөв бүртгэнэ.


5.2. Байнгын асаргаа тогтоосон болон сунгасан тухай шийдвэрийг Эрүүл мэндийн болон нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтран баталсан маягт дээр хобогдох эмч мэргэжилтнүүдийн гарын үсэг зурж баталгаажуулна.

5.3. Комиссын гишүүн бүр харилцан бие биеэ хүндэтгэж, үндэслэлтэй зөв шийдвэр гаргахыг эрхэмлэнэ.

5.4. Иргэний байнгын асаргааг тогтоох, сунгах, цуцлах үйл ажиллагаанд холбогдох дүрэм, журмыг зөрчсөн, тухайн иргэний нөхцөл байдалтай нийцэхгүй буруу шийдвэр гаргасан, хуурамч бичиг, баримт үйлдсэн эмч, эмнэлгийн байгууллагыг тухайн аймаг, нийслэл, дүүргийн Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хороонд хүргүүлэн дүгнэлт гаргуулж, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

-----oO-----





Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр
нийгмийн хамгааллын сайдын 2018 оны
02 дугаар сарын 23-ны өдрийн
18/02 дугаар хамтарсан тушаалын
тавдугаар хавсралт
А5 эхний нүүр

БАЙНГЫН АСАРГАА ШААРДЛАГАТАЙ ИРГЭНИЙ
ТОДОРХОЙЛОЛТ

201... оны дугаар сарын-ний өдөр

Тодорхойлолтын дугаар

.....аймаг, нийслэл
..... дүүрэг, сум, тосгон
..... баг, хороо

багийн.....-д оршин суугч
эцэг/эх/-ийн нэр.....нэр.....
Регистрийн дугаар.....нас.....хүйс.....

Өвчний онош.....

Өвчний олон улсын код.....

Байнгын асаргаа шаардлагатай хугацаа:

а/ 6 сар б/ 12 сар в/ 24 сар г/ 36 сар д/ давтан 36 сар

Байнгын асаргаа шаардлагатайг тогтоосон хугацаа:

.....оны дугаар сарын-ний өдрөөсоны дугаар сарын-
ний өдөр хүртэл хүчинтэй

A5 арын нүүр

ТОДОРХОЙЛОЛТ ГАРГАСАН:

Тэмдэг	Тэмдэг	Тэмдэг	Тэмдэг
.....аймагаймаг	айм
.....сум//дүүрэг/-ийн	Сэтгэцийн эрүүл/дүүрэг/-ийн
тосгоны	Эрүүл мэндийн төв,	мэндийн үндэсний	Хөгжлийн бэрхшээлтэ
Эрүүл мэндийн	нэгдсэн эмнэлгийн эмнэлэг	төвийн их эмч	хүүхдийн ЭМБНХ-ийн
төвийн эрхлэгч их эмч	хяналтын комисс		комисс
/...../	Дарга.....	/...../	Дарга.....
Гарын үсэг	Гишүүд	Гарын үсэг	Гишүүд
1.	1.		1.
	2.		2.
	3.		3.
	4.		4.
	5.		5.
	6.		6.

Санамж:

Байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний тодорхойлолтыг сум, тосгонд сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эрхлэгч их эмч, аймгийн төвийн сум, дүүрэгт аймаг, дүүргийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгийн эмнэлэг хяналтын комисс, төрөлхийн оюуны хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэцийн хүнд хэлбэрийн эмгэгтэй иргэний тодорхойлолтыг аймагт нэгдсэн эмнэлгийн эмнэлэг хяналтын комисс, нийслэлд Сэтгэцийн эрүүл мэндийн төв, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тодорхойлолтыг аймаг, дүүргийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс тус тус гаргана.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМ
ТБАГУТҮГ
ХУУЛБАР ҮНЭЭ
Гарын үсэг: *[Signature]*
2018 оны 04 сар 30 өдөр